



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛЭЭС

2019 оны 06 сарын 18 өдөр

Дугаар 14


Улаанбаатар хот

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 14 дүгээр хуралдааны тэмдэглэлд:

VI. ХЭЛЭЛЦСЭН нь: “Эрдэнэт үйлдвэр” ХХК (хуучин нэрээр)-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн төрийн өмчит үйлдвэрийн газар болгох хүртэл хугацааны цалин хөлсний тухай.

ШИЙДВЭРЛЭСЭН нь: 2.Засгийн газрын 2018 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн 07 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны 01 дүгээр сарын 09-ны өдрийн 10 дугаар тогтоол, 2019 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн хуралдааны 07 дугаар тэмдэглэл, “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын 2019 оны ХБ-108-12/805 дугаар албан бичгээр ирүүлсэн саналыг үндэслэн “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани (хуучин нэрээр)-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн тус компанийг Төрийн өмчит үйлдвэрийн газар болгох хүртэл хугацааны цалин хөлсийг тухайн үеийн үйлдвэрийн эрх бүхий албан тушаалтны сарын дундаж цалин хөлсөөр тооцож нөхөн олгох арга хэмжээг зохих журмын дагуу авах, Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны тайлан, Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр, хурлын дэлгэрэнгүй тэмдэглэл, шийдвэрийн хэрэгжилтийн тайлан, гишүүдийн ирцийн бүртгэл, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас өгсөн удирдамжийн хэрэгжилтийн тайланг нэгтгэн архивын нэгж болгохыг “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын Ерөнхий захирал Х.Бадамсүрэнд даалгав.” гэжээ.

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР



000041